



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 597

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны "Агентлаг байгуулах тухай" 272 дугаар тогтоолын 5 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 64.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 81,258,305.00 (наян нэгэн сая хоёр зуун тавин найман мянга гурван зуун таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газруудад балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг болон харьяа Шүүхийн тамгын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн элэгдлийг тооцож, хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Тогтоолын биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006550

31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА, АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРУУДЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нэгжийн үнэ (төгрөг)	Тоо	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтдагс ан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэх шүүхийн тамгын газрын нэр	Шилжүүлж авах шүүхийн тамгын газрын нэр
1	Шүүхийн байрны гадна фасадны зураг төсөв	2023.06.28	8,675,045.00	1	8,675,045.00	-	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба
2	Кабел утас дотор	12/31/2021	940.00	300	282,000.00	-	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба	Дархан-Уул аймгийн давж заалдах болон захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгы
3	Свич 24 порт 1000t	5/17/2022	277,860.00	1	277,860.00	-		
4	Сервер 940	12/30/2022	54,670,000.00	1	54,670,000.00	-		
5	Тог баригч APC 10000VA	6/2/2023	11,750,000.00	1	11,750,000.00	-		
6	Зөөврийн компьютер ASUS i7	12/22/2022	2,801,700.00	2	5,603,400.00	-	Баянзүрх Чингэлтэй Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгы газар	
Дүн				306	81,258,305.00	-		
					(наян нэгэн сая хоёр зуун тавин найман мянга гурван зуун таван)			